



**ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

**Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах  
асуудлыг дэмжих тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, Компанийн дүрмийн 4.3 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 525 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 23 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан компанийн дүрэмд дараах нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцээд, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр гаргасан саналыг дэмжсүгэй. Үүнд:

- 1.1. 4.2.13-т хөрөнгө оруулалтын судалгаа хийх чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх
- 1.2. 4.2.14-т барилгын ажлын үе шатанд хяналт тавих, барилга байгууламжийн ашиглалтын үеийн чанар, аюулгүй байдлын төлөвт дүгнэлт гаргах чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх
- 1.3. 4.2.15-т төслийн удирдлага, зохион байгуулалт, технологийн түвшин чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх
- 1.4. 4.2.16-т барилга байгууламжийн захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх

2. Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэн, шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Эрдэнэбулган/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Уянга/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ШИНЭХҮҮ